

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар/

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээ 2023 оны 6 сард хүлээгдэл бага, нийт 12 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байна.

Оношилгооны чиглэлээр MRI, КТГ маш их хүлээгдэлтэй, нийт 938 үйлчлүүлэгч 2-с дээш хоног багажийн шинжилгээ хийлгэхээр хүлээж байнгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй адил түвшинд байна./ Хүснэгт 1/.

**Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлэгт оношилгоо хийлгэхээр хүлээж
буй үйлчлүүлэгчдийн тоо**

№	Оношилгоо	Хүлээгдэл			Нийт
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	MRI	30	50	750	830
2	КТГ	108	-	-	108
	БҮГД	138	50	750	938

Тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамааралтайгаар тус эмнэлэгт MRI хийлгэхээр 830 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаагийн дийлэнх буюу 90% нь 15-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. КТГ хийлгэхээр 108 үйлчлүүлэгч хүлээж байна.

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд мөн адил маш их хүлээгдэлтэй, нийт 1326 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь өмнөх сараас 200 орчим үйлчлүүлэгчээр буурсан байгаа ба талаас илүү буюу 80% нь 1 сар ба түүнээс дээш хугацаагаар хүлээгдэлтэй байна /Хүснэгт 2/.

**Хүснэгт 2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж,
үйлчилгээний хүлээгдэл**

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Нүдний тасаг	3-6 хоног	18
		7-14 хоног	11
		15-30 хоног	80
		1 сараас дээш	600
	Нийт		709
2	Чих, хамар, хоолойн тасаг	3-6 хоног	-
		7-14 хоног	-
		15-30 хоног	-
		1 сараас дээш	350
	Нийт		350
3	Урологийн тасаг	3-6 хоног	15
		7-14хоног	20
		15-30 хоног	45
		1 сараас дээш	70
	Нийт		150
4	БШГМЗ тасаг	3-6 хоног	4

		7-14 хоног	8
		15-30 хоног	23
		1 сараас дээш	15
	Нийт		50
5	Зүрх судас судлал	3-6 хоног	-
		7-14хоног	2
		15-30 хоног	1
		1 сараас дээш	7
	Нийт		10
6	Мэс заслын тасаг	3-6 хоног	15
		7-14хоног	17
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
	Нийт		32
7	Цусны эмгэг судлал	3-6 хоног	2
		7-14хоног	3
		15-30 хоног	2
		1 сараас дээш	2
	Нийт		9
8	Хоол боловсруулах эрхтэн судлал	3-6 хоног	2
		7-14хоног	3
		15-30 хоног	2
	Нийт		7
9	Дотоод шүүрэл судлал	3-6 хоног	2
		7-14хоног	2
	Нийт		4
10	Мэдрэл судлал	3-6 хоног	-
		7-14хоног	-
		15-30 хоног	-
		1 сараас дээш	4
	Нийт		4
11	Уушиг судлал	3-6 хоног	-
		7-14хоног	-
		15-30 хоног	1
		1 сараас дээш	1
	Нийт		2
	БҮГД	3-6 хоног	58
		7-14хоног	66
		15-30 хоног	153
		1 сараас дээш	1049
	НИЙТ		1326

Нүдний тасагт хэвтэн эмчлүүлэх хүсэлтэй үйлчлүүлэгчийн тоо хамгийн их буюу 709 байгаа нь нүдний болор солих хагалгаанд орохоор хиймэл болор хүлээж буй үйлчлүүлэгчид байна. Эдгээр үйлчлүүлэгчид тус эмнэлгийн нийт хүлээгдлийн талыг буюу 53%-ийг эзэлж байна. Хүлээгдэлтэй 709 үйлчлүүлэгчдийн 600 буюу 654 үйлчлүүлэгчийн дийлэнх буюу 84% нь 1 сар ба түүнээс дээш хугацаагаар хүлээгдэлтэй байна. Мөн Чих, хамар, хоолойн тасагт хэвтэж эмчлүүлэхээр 350 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь бүгд 1 сараас дээш хугацаагаар ор хүлээж байна. Урологийн тасагт эмчлүүлэхээр 150 үйлчлүүлэгч хүлээж байна.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх сартай адил түвшинд байна. Нийт 103 үйлчлүүлэгч амбулаторийн 6 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд мэдрэл, нүдний эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Мэдрэл судлал	2	2	28	32
2	Мэс засал судлал	-	-	19	19
3	Зүрхний эмгэг судлал	1	-	15	16
4	Нүд судлал	-	-	15	15
5	Бөөр судлал	1	-	12	13
6	Чих хамар хоолой судлал	-	-	7	7
	НИЙТ	4	2	97	103

Амбулаторийн эмчийн үзлэг хийлгэхээр 97 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаагийн дийлэнх буюу 94% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 42 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас өөрчлөлтгүй байна. Хэвлийн эхо-д харуулахаар 21, Рентген оношилгоо хийлгэхээр 9, MRI оношилгоо хийлгэхээр 12 үйлчлүүлэгч тус тус хүлээж байна. Шинжилгээ өгөхөөр нийт 36 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа ба хамгийн олон буюу 25 үйлчлүүлэгч биохимийн шинжилгээ өгөхөөр хүлээж байна.

Тус эмнэлгийн орны хүлээгдэл өмнөх сараас 10 орчим үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэттэй, нийт 165 үйлчлүүлэгч 3-с дээш хоног ор хүлээж байна. Чих, хамар, хоолойн тасагт хэвтэхээр 60, мэс заслын болон зүрх судасны тасагт хэвтэхээр тус бүр 30 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үйлчилгээнд хамаарч байна. /Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Чих, хамар, хоолой судлал	-	-	25	35	60
2	Мэс засал судлал	2	26	2	-	30
3	Зүрх судасны эмгэг судлал	6	6	18	-	30
4	Хоол боловсруулах эрхтэн судлал	2	15	14	-	26

5	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	7	6	4	-	17
6	Урологи	7	4	-	-	11
7	Мэдрэл судлал	2	-	-	-	7
8	Уушиг судлал	-	3	-	-	3
9	Бөөрний эмгэг судлал	1	-	-	-	1
	НИИТ	18	49	63	35	165

3. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэлтэй байна. Эмчийн үзлэг хийлгэхээр нийт 465 үйлчлүүлэгч 4-с дээш хоногоор хүлээж байгаа нь өмнөх сараас 70 үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 96% /446/ нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. /Хүснэгт 5/.

Хүснэгт 5. Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо		Бүгд
		4-6 хоног	7-с дээш хоног	
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	-	94	94
2	Толгой, хүзүүний мэс засал	-	49	49
3	Хөхний төв	1	71	72
4	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	1	57	58
5	Хими	-	47	47
6	Зүрх судас судлал	-	21	21
7	Ерөнхий мэс засал	4	26	30
8	Туяа эмчилгээ	1	29	30
9	Ангиографи	2	34	36
10	Элэг судлал	-	18	18
	Нийт	9	446	465

Эмэгтэйчүүдийн мэс засалд үзүүлэхээр 94, Хөхний төвд үзүүлэхээр 72 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн үзлэгт хамаарч байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 4-с дээш хоногоор нийт 161 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтэй ойролцоо түвшинд байна. Эход харуулахаар 59, КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 51, Зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 17, ходоод дурандуулахаар 18, рентгенд харуулахаар 5, бүдүүн шулуун гэдэс дурандуулахаар болон хөхний зураг авахуулахаар тус тус 2, нийт 161 үйлчлүүлэгч 7-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй адил түвшинд байна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй, нийт 389 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс даруй 100 үйлчлүүлэгчээр буурсан байна. /Хүснэгт 6/.

Хүснэгт 6. Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Өдрийн хими	11	50	109	27	197
2	Хими	-	26	50	14	90
3	Ангиографи	5	12	21	5	43
4	Элэг, цес, нойр булчирхайн мэс засал	2	9	-	-	11
5	Хөнгөвчлөх	1	6	7	3	17
6	Өдрийн туяа	3	5	6	2	16
7	Толгой, хүзүүний мэс засал	-	-	3	2	5
8	Хөхний төв	-	3	2	-	5
9	Эмэгтэйчүүдийн мэс засал	-	2	1	2	5
	Нийт	22	113	199	55	389

Тус эмнэлэгт өдрийн хими эмчилгээ хийлгэхээр нийт 197 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй орны тоонд орж байна. Хүлээгдэл нэмэгдэхэд үйлчлүүлэгчид 14-21 хоногийн давтамжтай товлотт хими эмчилгээ хийдэг нь нөлөөлсөн байна. Хими эмчилгээ хийлгэхээр 90, ангиографиийн тасагт хэвтэхээр 43 үйлчлүүлэгч, ор хүлээж байгаа нь удаах хамгийн их хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд орж байна.

4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

Тус төвийн хүлээгдэл өмнөх саруудаас харьцангуй буурсан байна. Амбулаторийн тусламж, үйлчилгээний хувьд эмгэг сэтгэл судлалын үзлэгт хамрагдахаар 28 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 40 үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. Мөн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 53 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмөх сараас 71 үйлчлүүлэгчээр буурсан байна. Лаборатори болон оношилгооны чиглэлийн тусламж үйлчилгээ хүлээгдэлгүй ажиллажээ.

5. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулатори болон лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин Арьс харшлын тасагт хэвтэхээр 104 үйлчлүүлэгч 3-6 хоног, 15 үйлчлүүлэгч 7-14 хоног, 7 үйлчлүүлэгч 15-30 хоног, нийт 126 хүн хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сараас даруй 2 дахин буурчээ.

6. Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Өргөө, Амгалан амаржих газрууд, Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хүрээ амаржих газар ТМЭ, Геронтологийн үндэсний төв болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.